



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ХОНГОР ТООЦООНЫ ТӨВИЙН  
ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ**

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт / *Дархан-Уул аймаг Хонгор тооцооны төвийн засварын ажил гүйцэтгэх*  
гэрээний нэр:

Тендер шалгаруулалт / *ТБ/201901026*  
гэрээний дугаар:

Төсөв: *17,000,000 төгрөг*

**Улаанбаатар хот  
2019 он**

## НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Төрийн банк** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Дархан-Уул аймаг Хонгор тооцооны төвийн засварын ажил гүйцэтгэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 4-р сарын 03-ны өдрийн 11 цаг 00** минутаас өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем** ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **тухайн өдрийн 11 цаг 20 минутад** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем** ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс авна. Утас: 11-310103 /Дотуур дугаар: 6033, 6046, 1/.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>          | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>     | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                 | <b>3.1.</b> Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ: <ul style="list-style-type: none"><li>(а) Үнийн санал;</li><li>(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;</li><li>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</li><li>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</li><li>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</li></ul>  |
| <b>4. Тендерийн үнэ</b>                       | <b>4.1.</b> Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцгчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.<br><b>4.2.</b> Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.<br><b>4.3.</b> Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.<br><b>4.4.</b> Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна. |
| <b>5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b> | <b>5.1.</b> Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>6. Алдааг залруулах</b>                    | <b>6.1.</b> Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна: <ul style="list-style-type: none"><li>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;</li><li>(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;</li><li>(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргжүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ</li></ul>   |

захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТОӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн санал баталгаажуулж ирүүлнэ /маягтын дагуу/.</li> <li>2. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</li> <li>3. Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолтыг ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Тодорхойлолтын доод хэсэгт байрлах баркод болон тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаар гаргацтай байх шаардлагатай.</li> <li>4. Байгууллагын тухай танилцуулга ирүүлнэ.</li> <li>5. Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөв ирүүлнэ. /Төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 1-р сарын 13-ны 18-р тушаал, 2012 оны 6-р сарын 13-ны 181-р тушаалуудаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу тооцно. Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар заавал гүйцэтгэж ирүүлнэ/</li> <li>6. Ажил хийж гүйцэтгэх календарьчилсан хуваарийг баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>7. Тендерт оролцогч нь “Эрчим Хүчний Яам”-ны ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн “03.5.2 0.7-40.0 кгх/см<sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, ЦТП-ны угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах үйлчилгээ”-ийн тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</li> <li>8. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</li> <li>9. Харилцагч банк болгоноос хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тодорхойлолт авч ирүүлнэ.</li> <li>10. Төрийн банкны зүгээс тухайн тендерт оролцогчийн талаар харилцагч банк, харьяа татвар, шүүх, нийгмийн даатгалын хэлтэс болон бусад байгууллагад хандаж лавлагаа хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ.</li> <li>11. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын зураг, тоо хэмжээ, техникийн тодорхойлолтын дагуу чанарын өндөр түвшинд ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> <li>12. Чанарын баталгаат хугацаа 1 жил түүнээс дээш байна /Баталсан албан бичиг ирүүлнэ/.</li> <li>13. Баталгаат хугацаанд гарсан доголдлыг өөрийн зардлаар шуурхай засварлах ажлыг хийж гүйцэтгэнэ /Баталсан албан бичиг ирүүлнэ/.</li> <li>14. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг ирүүлнэ.</li> </ol>

	<p>15. Тендерт оролцогчийн ирүүлсэн үнийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</p> <p>16. 2017, 2018 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гэрээгээр хийж гүйцэтгэсэн туршлагын мэдээллийг ирүүлнэ.</p> <p>17. 2018 оны жилийн эцсийн баталгаажсан санхүүгийн тайлан ирүүлнэ /Сангийн яамны И-Баланс цахим системд шивэгдэж баталгаажсан байх/.</p> <p>18. Ашигтай ажилласан байх жилийн тоо: 2018 он.</p> <p>19. Борлуулалтын орлогын хэмжээ: 2018 оны борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.</p> <p>20. Голлох боловсон хүчний мэдээллийг ирүүлнэ.</p> <p>21. Хувилбарт үнийн санал ирүүлэхгүй.</p> <p>22. Тендерийн баримт бичгийг ТОӨЗ 1.1-д заасан дарааллын дагуу эмхтгэж, дугаарлаж ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тендерийн хэл нь Монгол хэл дээр байна.</li> <li>• Гадаадын этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.</li> <li>• ТШӨХ-т заасан баримт бичгүүдээс аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд татгалзах үндэслэл болно.</li> </ul>
ТОӨЗ 2.1	<p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b></p> <p><b>2019 оны 4-р сарын 03-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д цахим хэлбэрээр хүлээн авна.</b></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн цагаар тоологдох, Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ, нэг файлын хэмжээ зэрэг нь хязгаарлагдмал байдаг зэргийг анхаарна уу. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТОӨЗ 2.1	<p><b>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</b></p> <p><b>Байгууллагын хаяг:</b> Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, 2-р давхар, 202 тоот өрөө.</p> <p><b>Огноо:</b> 2019 оны 4-р сарын 03-ны өдөр.</p> <p><b>Цаг:</b> 11 цаг 20 минут</p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцүй</b>

# Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

/Дархан Хонгор тооцооны төвийн гадна дулаан шугам сүлжээний ажил/

Ажлыг батлагдсан зураг төсөл болон холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу хийж гүйцэтгэнэ.

### 1. Ерөнхий шаардлага:

- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм 1-р хэсэг, 2-р хэсэг - Ерөнхий шаардлага БНБД 12.03.04, БНБД 12.04.06, Барилгын талбайн зохион байгуулалтын зургийн тэмдэглэгээ MNS 5145:2004 стандартыг тус тус мөрдөж ажиллана.
- Ажлын талбайн зохион байгуулалт болон ажилтнуудын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх ба ажилтнууд хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангагдсан байна.
- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм дүрэм, стандартыг мөрдөж ажиллаагүйгээс гарах эрсдлийг гүйцэтгэгч компани бүрэн хариуцна.
- Барилгын ажлын явцад гарсан хог хаягдлыг зөөвөрлөн, төвлөрсөн хогийн цэгт хаяна.
- Гүйцэтгэгч нь ашиглагч болон захиалагч, захиалагчийн хяналтын төлөөлөлтэй нягт уялдан ажиллах шаардлагатай.
- Барилгын ажлыг батлагдсан зураг, төслийн дагуу гүйцэтгэж, ажлыг үе шат бүрт захиалагчийн хяналтын инженерт үзүүлж, фото зургаар баталгаажуулан, акт үйлдсэний дараа дараагийн ажил үргэлжлүүлэн хийх зөвшөөрлийг авч ажиллана.

### 2. Ажилд тавигдах шаардлага:

**Гадна шугам сүлжээний ажил**

**Техникийн нөхцлийн дагуу гүйцэтгэх.**

### 3. Ажилд хэрэглэгдэх барилгын материалд тавигдах шаардлага:

Ашиглаж буй материалууд нь чанарын хувьд олон улсын хэмжээнд болон Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартыг бүрэн хангасан байх. /БНБД, стандартад нийцсэн байна/

### 4. Бусад шаардлага:

- Хэрвээ засварын ажлын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор албан бичгээр хариу ирүүлээгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Үнийн саналаа ирүүлэхээс өмнө ажлыг газар дээр нь очиж танилцаж, хийгдэх ажлыг хэмжсэн байх шаардлагатай. Ажлын төсөвт өртгийг тооцохдоо ажлын тоо хэмжээний жагсаалтад өгөгдсөн хэмжээгээр тооцох ба техникийн тодорхойлолтод хийгдэхээр заагдсан боловч ажлын тоо хэмжээний жагсаалтад тусгагдаагүй орхигдсон ажил, газар дээр нь очиж үзэхэд их засварын ажлыг гүйцэтгэхэд заавал хийгдэх шаардлагатай хэдий ч ажлын тоо хэмжээнд мөн тусгаагүй ажилууд гарах тохиолдолд тус ажлыг нийт төсөвт өртөгтөө тооцож ирүүлэх ба ингэж ирүүлээгүйгээс орхигдсон ажлыг гүйцэтгэгч өөрийн зардлаар хийнэ.

Батлав: Дарга *Дархан-Уул аймаг* Ариунболд



## ДУЛААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ

### ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

№ 01

2018 оны 07-р сарын 25-ны өдөр

Дархан-Уул аймаг

1. Барилга объектын нэр, хаяг: ....Төрийн банкны салбар, Хонгор сум 1-р баг .....
  2. Барилга объектын байршил: ....Хонгор сум 1-р баг Ахмадын байрны залгаа...
  3. Дулааны тооцоот ачаалал: 200м<sup>3</sup> барилга
  4. Дулааны холболт хийх цэг:.....7-р байрны урд талын худаг.....
  5. Дулааны эх үүсвэр: Төвлөрсөн дулаан
  6. Холбох шугамын диаметр: 80см-ийн диаметр
  7. Холбох шугамын урт: 100м урт хос шугам
  8. Холбох хэрэгсэл: ф80 ган бөмбөлгөн хаалт, гагнаадаг булан 8ш
  9. Холболт хийж буй шугамын лоткинд зориулалтын таг, хавтан тавих.
10. Ерөнхий шаардлага:
- 10.1 Холболтыг “Төвлөрсөн дулаан хангамжийн хурээнд мөрдөх холболтын журам”-ийн дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.
  - 10.2 Шугам хоолой, хаалт арматурыг хөлдөлтийн гүнээс доор байрлуулж сайтар дулаалсан байх.
  - 10.3 Хэрэглэгчид нь мэргэжлийн эрх бүхий байгууллага, хуулийн эдгээдээр дулааны шугамын зураг төслийг хийлгэнэ.
  - 10.4 Зураг төсөл зохиогч нь техникийн нөхцөлийн дагуу “ЭмтНаран”ОНӨААТҮГ-тай зөвшилцөл хийж зургийн 1%-г техникийн нөхцөл олгогчид өгнө.
  - 10.5 Батлагдсан зураггүй буюу зөвшилцөл хийгээгүй зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.
  - 10.6 Хэрэглэгчийн дулааны шугамын угсралтын ажил хийхэд газар доорхи бусад инженерийн сүлжээг отголж гаргах, зам талбай, мод бут сөөг эвдэх тайрах, тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөвт тусгана.
  - 10.7 Хэрэглэгч нь шугам сүлжээг угсралт явцад бусад инженерийн шугам сүлжээг хамгаалж бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.
  - 10.8 Хэрэглэгч нь батлагдсан зураг төслийн дагуу дулааны шугам сүлжээний угсралтын ажлыг “ЭмтНаран”ОНӨААТҮГ-ийн техникийн ажилтаны хяналт зөвлөмжийн дор гүйцэтгэнэ.

11. Хэрэглэгч дулаан хангамжийн угсралтын ажлыг хийж дуусгасаны дараа техникийн нөхцөл олгогчийн төлөөлөгчийг байлцуулан шахалт угаалгыг хийж холбогдох акт баримтуудыг бүрдүүлсэн байна.

Үүнд:

- Ажлын зураг, түүнд зураг төслийн байгууллагатай зөвшөөрөлцөж оруулсан өөрчлөлтүүд
- Гүйцэтгэлийн зураг
- Хэсэгчлэн хулээн авсан ажлын зургууд
- Хэмжүүрийн гэрчилгээ
- Цэвэр усны шинжилгээ хийлгэсэн бичиг

12. Дулааны хэмжүүрийн зангилааг үзлэг хийхэд тохиromжтой ус тусгаарлагчтай, гэрэлтүүлэгтэй +5 хэмээс дээш температуртай өрөөнд байрлуулна.

13. Уг барилгыг барих талаар дээд байгууллагын тогтоол шийдвэрийн заалт: **Газар олголтын тогтоол 2018 оны 4-р сарын 4 –ны өдөр 44 тоот**

14. Техникийн нөхцөл олгосон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй. Техникийн нөхцөлийн хугацаа дууссан үед хэрэглэгч нь техникийн нөхцөл олгосон газарт хандаж дахин шинээр техникийн нөхцөл авна.

15. Техникийн нөхцөлийг 2% үйлдэж холбогдох газруудад хүргүүлнэ.

16. Техникийн нөхцөлийн шаардлагуудыг хэрэглэгч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй.

17. Техникийн нөхцөлийн үндсэн төлбөрийг огтолгоо заах шугамын диаметр болон барилга объектын тооноос үл хамааруулан 110000 төгрөг/НӨАТ орсон/ авна.

18. 4-р сарын 01-нээс 10-р сарын 15-ны хооронд огтолгоо авч холболт хийсэн байх шаардлагатай.

19. Техникийн нөхцөлийг дур мэдэн хангагчид мэдэгдэлгүй өөрчилсөн тохиолдолд техникийн нөхцөлийн үнийг 5 дахин өсгөж торгууль ноогдуулна.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

“ЭМТНАРАН”ОНӨААТҮГ-ийн

Ерөнхий инженер:

Ж.Батцэцэг

Механик: Ш.Огтонбаатар

**Техникийн нөхцөл олгоход мөрдөх үнэлгээ**

Хүснэгт 1

№	Хураамжийн төрөл	Хураамжийн төлбөр	Тайлбар
1.	Газрын зөвшөөрөл	9000	
2.	Техникийн нөхцөл авахад: A. Ф20-Ф50 Б. Ф80-Ф100 В. Ф125-Ф200	77000 154000 231000	
3.	Техникийн нөхцөл яаралтай гарах хураамж A. Ф20-Ф50 Б. Ф80-Ф100 В. Ф125-Ф200	100000 230000 300000	Журамын 4.6 заалтыг харгалзахгүй олгох

Жич. Хураамжид НАӨТ тооцогдсон болно.

**Ф15-Ф500мм хүртэлх 1 метр шугамын дүүргэлтийн хүснэгт /литрээр/**

Хүснэгт 2

№	Диаметр	1м шугамын усны дүүргэлт /литр/
1	Ф15	0.176
2	Ф20	0.314
3	Ф25	0.49
4	Ф32	0.804
5	Ф40	1.258
6	Ф50	1.963
7	Ф80	5.02
8	Ф100	7.85
9	Ф150	17.66
10	Ф200	31.4
11	Ф250	48.06
12	Ф300	70.68
13	Ф400	125.6
14	Ф500	196.25

- Жич:
1. Барилга орон сууцны дотор угаалтyg тоолуурын заалтаар тооцно.
  2. Барилгын гадна шугамын дүүргэлтийг хүснэгтийн дагуу уртаар тооцон авна.
  3. Лабораторын шинжилгээний үнэ 40000төгрөг /наэт-гүй үнэ/
  4. 1m<sup>3</sup> усанд ариутгал хийх хлорамины орц 0,4кг тунгаар хийгдэнэ.
  5. Техникийн нөхцөлийн дагуу бүрэн холболт хийж шаардагдах хэмжээний тунгаар халдвартгүйжүүлж даралт бууруулахгүй 3 хоног байлгаж шинжилгээ хийгдсэний дараа системийг бүрэн угаана.



Батлав: Дарга *Х.Чижүүлэгч* Д.Ариунболд

**ЦЭВЭР УСААР ХАНГАХ  
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ**

№ 01

2018 оны 07-р сарын 25-ны өдөр

Дархан-Уул аймаг

1. Барилга объектын нэр, хаяг: ....Төрийн банкны салбар, Хонгор сум 1-р баг .....
2. Барилга объектын байршил: ....Хонгор сум 1-р баг Ахмадын байрны залгаа...
3. Цэвэр усны тооцоо: а. Ахуйн ундны хэрэгцээ - 0.5 м<sup>3</sup>/хон  
б. Технологийн хэрэгцээ - 0 м<sup>3</sup>/хон  
в. Галын зориулалттай - л/с  
Бүгд м<sup>3</sup>/хон
4. Цэвэр усны холболт авах цэг:.....7-р байрны урд талын худаг.....
5. Усан сангийн эх үүсвэр: Төвлөрсөн ус хангамжийн систем
6. Холбох шугамын диаметр: 50см-ийн диаметр
7. Холбох шугамын урт: 100м урт
8. Холбох хэрэгсэл: ф50 ган бөмбөлгөн хаалт, гагнадаг булан 4ш
9. Бохир ус: а. Ахуйн хэрэгцээнээс гарах - ...0.5 м<sup>3</sup>/хон....  
Б. Технологийн хэрэгцээнээс гарах - ...0 м<sup>3</sup>/хон .....
10. Бохир усны шугам холбох цэг: .....Хүн эмнэлэгийн урд талын худагт.....
11. Хотын төв шугаманд нийлүүлэгдэх бохир усны найрлага:
  - A. Умбуур бодис
  - Б. БПК
  - В. ХПК
  - Г. Угаагч бодис
  - Д. Бусад хорт бодис
12. Ерөнхий шаардлага:
  - 12.1 Холболтыг "Ус хангамж бохир ус татуургын гадна сүлжээ барилга байгууламж" БНБД 3.05.04-90 дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.
  13. Шугам хоолой, хаалт арматурыг, арматуруудыг хөлдөлтийн гүнээс доор байрлуулах.
  - 13.1 Хэрэглэгчид нь мэргэжлийн эрх бүхий байгууллага, хуулийн этгээдээр цэвэр бохир усны шугамын зураг төслийг хийлгэнэ.

- 13.2 Зураг төсөл зохиогч нь техникийн нөхцөлийн дагуу "ЭмтНаран"ОНӨААТҮГ-тай зөвшилцөл хийж зургийн 1%-г техникийн нөхцөл олгогчид өгнө.
- 13.3 Батлагдсан зураггүй буюу зөвшилцөл хийгээгүй зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.
- 13.4 Хэрэглэгчийн ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээний угсралтын ажил хийхэд газар доорхи бусад инженерийн сүлжээг огтолж гаргах, зам талбай, мод бут сөөг эвдэх тайрах, тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөвт тусгана.
- 13.5 Хэрэглэгч нь шугам сүлжээг угсрах явцад бусад инженерийн шугам сүлжээг хамгаалж бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.
- 13.6 Хэрэглэгч нь батлагдсан зураг төслийн дагуу ус хангамж ариутгах татуургын сүлжээний угсралтын ажлыг "ЭмтНаран"ОНӨААТҮГ-ийн техникийн ажилтаны хяналт зөвлөмжийн дор гүйцэтгэнэ.
14. Хэрэглэгч нь усан хангамж ариутгах татуургын системийн угсралтын ажлыг хийж дуусгасаны дараа техникийн нөхцөл олгогчийн төлөөлөгчийг байлцуулан шахалт угаалгыг хийж холбогдох акт баримтуудыг бүрдүүлсэн байна.


Үүнд:

- Ажлын зураг, түүнд зураг төслийн байгууллагатай зөвшөөрөлцөж оруулсан өөрчлөлтүүд
  - Гүйцэтгэлийн зураг
  - Хэсэгчлэн хүлээн авсан ажлын зургууд
  - Хэмжүүрийн гэрчилгээ
  - Цэвэр усны шинжилгээ хийлгэсэн бичиг
- 14.1 Хэрэглэгч нь сүүлийн үеийн дэвшилтээ технологи бүхий соронзон хамгаалалттай тоолуур тавиулна.
- 14.2 Тухайн барилгын ус хангамжийн гадна сүлжээнд гал унтраах гидрант тавина.
15. Усны хэмжүүрийн зангилааг үзлэг хийхэд тохиромжтой ус тусгаарлагчтай, гэрэлтүүлэгтэй +5 хэмээс дээш температуртай өрөөнд байрлуулна.
16. Уг барилгыг барих талаар дээд байгууллагын тогтоол шийдвэрийн заалт: Газар олголтын тогтоол 2018 оны 4-р сарын 4 -ны өдөр 44 тоот
17. Техникийн нөхцөл олгосон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй. Техникийн нөхцөлийн хугацаа дууссан үед хэрэглэгч нь техникийн нөхцөл олгосон газарт хандаж дахин шинээр техникийн нөхцөл авна.
18. Техникийн нөхцөлийг 2% үйлдэж холбогдох газруудад хүргүүлнэ.
19. Техникийн нөхцөлийн шаардлагуудыг хэрэглэгч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй.

20. Техникийн нөхцөлийн үндсэн төлбөрийг огтолгоо заах шугамын диаметр болон барилга объектын тооноос хамааруулан авна. Хавсралт 1
21. 4-р сарын 01-нээс 10-р сарын 15-ны хооронд огтолгоо авч холболт хийсэн байх шаардлагатай.
22. Техникийн нөхцөлийг дур мэдэн хангагчид мэдэгдэлгүй өөрчилсөн тохиолдолд техникийн нөхцөлийн үнийг 5 дахин өсгөж торгууль ноогдуулна.
23. Бохир усны шугам холбох боломжгүй нөхцөлд "ЭМТНАРАН"ОНӨААТҮГ-тай гэрээ хийж, зориулалтын авто машинаар бохир усыг соруулж зайлцуулна.

**ТЕХНИКИЙН НӨХЦӨЛТ ОЛГОСОН:**

**"ЭМТНАРАН"ОНӨААТҮГ-ИЙН**

Ерөнхий инженер:  Ж.Батцэцэг  
Механик:  Ш.Отгонбаатар

**ТАБ. ЗУРАГ**

## Зургаа. YE ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Т?рийн банк

Дархан Хонгор тт-ын гадна шугам с?лжээний ажил

### АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

#### ХАЛААЛТЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Рж=1.6 мпа даралттай 150 хэм халуун ус дамжуулах гарцгүй сувагт яндан хоолой тавих хоолойн голч 80 мм	км	0.2
2	Цэвэр ус дамжуулах яндан хоолойг газар дээр тавих хоолойн голч 50мм	км	0.1
3	0.5м3 багтаамжтай шанагат экскаватороор 1-р зэргийн хөрсийг ухаж овоолох	м3	1500
4	2 м хүртэл гүн шуудууг бэхэлгээгүйгээр 1-р зэргийн хөрсөнд гараар ухах	м3	77.4
5	Сувгийн таг угсрал 80*120мм	ш	48
6	Фланц ба арматурын голч d=80мм байрлуулах	ш	2
7	Рж=1.6 мпа даралттай 150 хэм халуун ус дамжуулах яндан хоолойд чиг өөрчлөгч тавих 80 мм	ш	8
8	Тусгаарлах гадаргууг лакаар будах	м2	55.8
9	Онц хүчитгэсэн битум, полимер тусгаарлалт. яндан хоолойн голч d = 50мм	км	0.2
10	Яндан хоолойг шилэн хавтан, хагас дугуй хавтангаар бүрэх	м2	8
11	Шилэн сүлжмэлээр буюу лак шилэн даавуугаар бүрэх	м2	55.8
12	Шахаж шалгах яндан хоолойн голч-200мм	м	200
13	Шугам хоолойг хлортой усаар угаах. хоолойн голч d = 300мм	км	0.2

**Долоо. ЖИШИГ МАЯГТ**  
**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>  | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.   |

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэл заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлне. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.  
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ.  
Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоон. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ec. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Дархан-Уул аймаг Хонгор тооцооны төвийн засварын ажил гүйцэтгэх”, ТБ/201901026
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь: “Дархан-Уул аймаг Хонгор тооцооны төвийн засварын ажил гүйцэтгэх” бусад гэрээтэй холбогдох байдалаас бүрдэнэ.  Ажлын талбай нь: Хавсралтад зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь: Төрийн банк, Төв байр, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр нь: Гэрээнд заасан хугацаагаар  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээнд заасан хугацаагаар
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <b>1 жил</b> байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5 хувь байна.  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “тэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;

- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;  
**5.9.** Санхүүжилтийн хуваарь;  
**5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]